



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД

2021.09.16 № 03/2107
танай _____-ны № _____-т

Шинжээч сонгон шалгаруулах
зар хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд “Дотоодын эмийн үйлдвэрлэл, үйлдвэрлэсэн эмийн найрлага дахь идэвхт бодисын хэмжээ стандартын шаардлага хангаж буй эсэх, эмийн үнийг бодитой тогтоосон эсэхэд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах, мэргэжлийн тусалцаа үзүүлэх” зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Эмийн үйлдвэрлэл, бүртгэл, түгээлт, хадгалалт, үнэ бүрдэл, чанар, хүртээмж, зохистой хэрэглээ, хяналтын тогтолцооны үр нөлөөнд судалгаа хийх, дүгнэлт гаргах, эрдэм шинжилгээний ажил хийсэн туршлагатай, эм зүйн мэргэжлээр мэргэшсэн хүний нөөц бүхий шинжээчийн баг, хуулийн этгээдийг аудитад шинжээчээр ажиллуулах шаардлага үүссэн бөгөөд шинжээч нь дотоодын эмийн үйлдвэрлэлийн сүүлийн 5 жилийн судалгаа, тоо мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэсэн эмийн идэвхт бодисын хэмжээ стандартын шаардлага хангаж буй эсэх, эмийн үнийг бодитой тогтоосон эсэхэд харьцуулсан судалгаа, лабораторийн шинжилгээ хийж, хяналт, зохицуулалт, бодлогын чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд болон эмийн үйлдвэрүүд, эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг хамруулж, нь тус зөвлөх үйлчилгээг 2 хүртэл сарын хугацаанд гүйцэтгэх ба дараах ажилбаруудыг хэрэгжүүлж, аудитын талбарын болон тайлагналын үе шатны үйл ажиллагаанд шаардлагатай мэргэжлийн, шинжлэх ухааны үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. Үүнд:

- Эмийн үндэсний үйлдвэрлэлд шинэ техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлсэн эсэх, энэ нь эмийн үнэд хэрхэн нөлөөлсөн талаар шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- Импортыг орлох, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлсэн эсэх талаар судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- Ургамал, амьтан болон эрдсийн гаралтай уламжлалт эм, эмийн бэлдмэл үйлдвэрлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн төсөл, судалгааны ажил зэрэгт төрөөс дэмжлэг үзүүлсэн эсэх талаар судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

- Дотоодын эмийн үйлдвэрлэл, түүнд шаардагдах эмт бодисын гарал үүсэл, эмийн найрлага дахь идэвхт бодисын хэмжээ стандартын шаардлага хангаж буй эсэхэд судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах;
- Дотоодод үйлдвэрлэсэн эмийн үйлчлэлийг эм зүй, эм судлал, эмнэлзүйн судалгаагаар нарийвчлан тогтоосон эсэхийг судалж, тогтоох;
- Дотоодод үйлдвэрлэсэн эмийн үнийг бодитой тогтоосон эсэхийг судалж, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг болно.

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичиж, гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Иймд мэдээллээ ирүүлж буй зөвлөх шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний 2018,2019,2020 оны мэдээлэл;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жил /2019, 2021 он/-ийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлт.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/;

Шинжээч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, эм зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагууд болон эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч, борлуулагч, бусад хамаарал бүхий этгээдээс гэрээт ажил үүрэгт нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байж, гэрээгээр хүлээсэн үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага: Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;
- Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргасан туршлагатай байх;
- Төрөөс эмийн талаар гаргасан бодлогын хэрэгжилт, эмийн үйлдвэрлэл, бүртгэл, түгээлт, хадгалалт, үнэ бүрдэл, чанар, хүртээмж, зохистой хэрэглээ, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан туршлагатай байх;

- Эмзүй, эмнэлзүйн судалгаа, эрдэм шинжилгээний үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байх;
- Өөрийн судалгаа, шинжилгээний лабораторитой байвал давуу байдал болно.

Ажиллах хүчний шаардлага:

- Эмзүй, эмнэлзүйн талаар судалгаа хийж, дүн шинжилгээ боловсруулах мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Эмзүй, эмнэлзүйн нарийн мэргэжлийн эрдэм шинжилгээний 3-аас дээш ажилтантай байх.

Багийн хувьд:

- Эмзүйн зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх;
- Эрүүл мэндийн болон эмзүйн салбарын хууль, тогтоомж, норм, нормативын баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргаж байсан туршлагатай байх;
- Мэргэжлийн англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
- Эрүүл мэнд, эм зүйн чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан туршлагатай байх;
- Багийн ахлагч болон гишүүд нь эм зүй, эмнэл зүйн чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан болон эрүүл мэнд, эм зүй, эмнэл зүйн шинжээч, судлаач, эрдэмтэн, эрдэм шинжилгээний чиглэлээр мэргэшсэн байх.

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.


Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба Түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 17 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 09 цаг 00 минутын дотор цахим /pdf файл/ хэлбэрээр дараах хаягаар илгээнэ үү.

Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068. Хугацаа хоцроосон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Захиалагчийн хаяг: 15160.Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, Үндэсний аудитын газар,
Утас: 51-263533. www.audit.mn

ТАМГЫН ДАРГА



Ц.ГАНБОЛД